



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/229

Зуунмод

Шинэ сэргэлтийн бодлого
“Орон нутагт хууль сахиулах байгууллагуудын
хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сэдэвт
зөвлөгөөн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ сэргэлтийн бодлого-“Орон нутагт хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сэдэвт зөвлөгөөнийг 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдөр аймгийн төвд зохион байгуулсугай.

2. Зөвлөгөөн зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ц.Буманбуян (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

А.Батцэцэг (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Нутгийн удирдлага, бодлого төлөвлөлтийн тасгийн дарга, зөвшилцсөнөөр)

Д.Магвансүрэн (Аймгийн Шүүхийн Тамгын хэлтсийн дарга, зөвшилцсөнөөр)

Ц.Нямтайван (Аймгийн Прокурорын газрын дарга, Хууль цаазын шадар зөвлөх, зөвшилцсөнөөр)

Л.Энхбаатар (Төв аймаг дахь Тагнуулын хэлтсийн дарга, хурандаа, зөвшилцсөнөөр)

Ч.Алтанхуяг (Аймгийн Цагдаагийн газрын дарга, дэд Хурандаа)

С.Өлзийбат (Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хурандаа)

Ө.Сэр-од (Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны дарга,

Н.Энхбат (Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Б.Ганхуяг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

3. Зөвлөгөөний дотоод зохион байгуулалт хангах дэд Ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

4182010648

Дэд ажлын хэсгийн дарга:

Б.Ганхуяг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүдэд:

А.Батзаяа (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны ГХУС-х зөвлөлийн Нарийн бичгийн дарга, зөвшилцсөнөөр)

Д.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын тасгийн дарга)

Э.Баярбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлчилгээний албаны дарга)

Л.Цэрэнноров (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Д.Сэдэд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Э.Ганхуяг (Төрийн үйлчилгээний мэдээллийн төвийн ахлах ажилтан)

Ц.Ууганбаатар (Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн ажилтан)

Нарийн бичгийн дарга:

Г.Ганбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

4. Зөвлөгөөнд оролцох байгууллага, албан тушаалтныг нэгдүгээр, зөвлөгөөн зохион байгуулах үйл ажиллагааны зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

5. Зохион байгуулалтад шаардагдах зардалд 5,020,000 (таван сая хорин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт), шилэн дансанд байршуулахыг төсвийн Ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

6. Зөвлөгөөний хөтөлбөр, бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө батлуулан товлосон хугацаанд өндөр хэмжээнд зохион байгуулж, коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллахыг Ажлын хэсэг (Ц.Буманбуян)-т үүрэг болгосугай.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Б.Оюунтуяа
Санхүүжүүлэгч.

Г.Сурмаа

04/5

Аймгийн Засаг даргын 2022 оны 04 -р сарын 21 -ны өдрийн А/222/р захирамжийн 1 -р хавсралт

ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦОХ БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАН

№	Байгууллагын нэр	Оролцох албан тушаалтны тоо
1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Ажлын алба	3
2	Аймгийн Засаг даргын Тамгын газар	3
3	Аймгийн Шүүх	5
4	Аймгийн Прокурорын газар	5
5	Төв аймаг дахь Тагнуулын хэлтэс	3
6	Төв аймаг дахь Цагдаагийн газар	10
7	Төв аймгийн Онцгой байдлын газар	3
8	Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	5
9	Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба	5
10	Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газар	3
11	Төв аймгийн Байгаль орчин, аялал жуучлалын газар	2
12	Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	5
13	Төв аймгийн Татварын хэлтэс	2
14	Баян суманд дахь 415 дугаар нээлттэй хаалттай хорих анги (дарга)	1
15	Мөнгөнморьт суманд дахь 417 дугаар нээлттэй хорих анги (дарга)	1
16	Согтуурах мансуурах донтой өвчтнийг эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар (дарга)	1
17	Гадаадын иргэн харьяатын газрын Агаарын замын боомт хариуцсан газрын Төв аймаг дахь төлөөлөл	1
18	Хүний эрхийн үндэсний комиссын Төв аймаг дахь төлөөлөл	1
19	Хууль зүйн туслалцааны төвийн Төв аймаг дахь салбар	1
Нийт		60
Урилгаар оролцох байгууллага		
1	Хууль, зүй дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	2
2	Цагдаагийн Ерөнхий газар	2
3	Авлигатай тэмцэх газар	1
4	Гадаадын иргэн харьяатын газар	1
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар	1
6	Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэн	1
7	Улсын бүртгэлийн Ерөнхий газар	1
8	Архивын Ерөнхий газар	1
9	Хүний эрхийн үндэсний комисс	1
10	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	1
Нийт		12
1	Бусад оролцогч	18
БҮГД		90

__оОо__

Аймгийн Засаг даргын 2022 оны 04 -р сарын 21 -ны өдрийн А/2022-р захирамжийн 2 -р хавсралт



ЗӨВЛӨГӨӨНИЙ ДОТООД ЗОХИОН
БАЙГУУЛАЛТАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Анонс хэвлэх	25 м	10000	250000
2	Товхимол бэлтгэх	100 ш	5000	500000
3	Видео шторк бэлтгэх	1 ш	500000	500000
4	Мандат	100 ш	2500	250000
Нийт			517500	1500000

ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦОГЧДЫН ЗАРДАЛ

№	Зардлын нэр	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Өдрийн хоол	90	18000	1620000
2	Цайны завсарлага (2 удаа)	100	10000	1000000
3	Хүндэтгэлийн арга хэмжээ	35	-	900000
Нийт				3520000

ТӨСӨВ ГАРГАСАН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН *Л.Цэрэнноров* Л.ЦЭРЭННОРОВ

ХЯНАСАН:
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Ч.Цэцэгсүрэн* Ч.ЦЭЦЭГСҮРЭН